



Н. Наранжаргал

**ЖА ЛАМЫГ УСТГАХ АЖИЛЛАГА БА
ХАЛИМАГ СУРГАГЧ НАР**

XX зуунд Монголчууд Манжийн дарлалаас гарч өөрсдийн тусгаар тогтонолыг зарласан нь дэлхийд тархан суусан монгол туургатануудын анхаарлыг татаж, улмаар тэдний зарим төлөөлөгчид Монгол улсад ирж тухайн үед өрнөөд байсан улс төрийн үйл хэрэгт биечлэн оролцох болсон.

Тэдний нэг бол Астархан мужийн Халимагийн Бага дөрвөд улсаас гаралтай Дамбийжанцан юм. Монголын баруун хязгаарын түшиц газар болох Ховд хотыг Манж, Хятадаас чөлөөлөхөд идэвхийлэн оролцосон түүний гавьяа зүтгэлийг Богд Хаант Монгол Улсын засгийн газраас өндөрөөр үнэлэн «Эрдэнэ бишрэлт хүчин төгөлдөр догшин ноён худагт номун хан цол, тамга сайдын зэргээр шагнасан» [Сүхбаатар 2011: 46]. Энэ үеээс эхлэн түүний алдар цуу Монгол газарт улам нэмэгдсэн. Тэрээр тухайн үеийн монголын газар нутгийн зарим хэсгийг бараг «35 жил ховсдолтын байдалтай байлгаж...: Астарханаас Бээжин, Өргөөгөөс Энэтхэгийг хүртэлх...» [Рерих 1982: 48] өргөн уудам нутагт алдар цуу нь мандаж үйл ажиллагаагаа явуулж байв. Ямар хүсэл зоригтой, ямар санаа агуулж явдаг нь бүү хэл, хаанаас гаралтай хэн болох нь одоо хүртэл нарын тодорхой бус тэрээр Ховдыг чөлөөлсөний дараа баруун хязгаарын сайдаар томилогдон ард олонд ихээхэн хатуу хандан, дур зоргоороо аашлах болсоноор Автономит Монголын засгийн газраас «баруун хойт монголд оршин суухдаа ардуудыг өдөн хатгах, хууран мэхлэх ажиллагаа явуулан ард олонд асар их

хохирол үзүүлэх болсон» [Ломакина 2011: 181] гэдэг үндэслэлээр бүх хэргэм цол мяндагыг хураан авч Хаант Оросын засгийн газарт мэдүүлэн баривчлуулан хориулсан. Гэсэн хэдий ч тэрээр Орос улсад гарсан хувьсгалын дараа 1918 онд дахин Баруун монголд ирж урьдын хамжиллагаа захиран суусан. 1920 онд Барон Унгерн нийслэл хүрээг чөлөөлсөн үйл явдалд түүний оролцоо байсан гэж үздэг. 1921 онд Монголд ардын хувьсгал ялсаны дараа ардын засгийн газрын ерөнхий сайд «Д. Бодоо баруун монголд ихээхэн нэр хүндтэй түүний амрыг нь эрсэн бичгийг хадгийн хамт хүргүүлж» байв [НЭПКО 2013: 24]. Монголын ардын засгийн газар түүний баруун монгол дахь нэр хүндийг ашиглахыг хүсчж байв. Жа лам нь ардын засгийн газартай хамтран ажилаагүйгээр барахгүй Монгол, Шинжаан, Алшаагийн нутгийн зааг Маажаасан ууланд бэхлэлт байгуулан суусан. Энэ нь шинээр тусгаар тогтнолоо зарласан Монгол улсын бүрэн бүтэн байдалд сөргөөр нөлөөлөх болсноор түүнийг устгах шаардлагтай болсон. Энэхүү ажиллагаанд тухайн үед Монголд ажиллаж байсан Зөвлөлтийн сургагч нар бас оролцосон. Иймээс түүнийг зарим судлаачид Хаант Оросын тагнуул хэмээн үздэг. Тухайн үед Зөвлөлтийн засгийн газар өөрсдийн сургагч нараараа дамжуулан ардын засгийн газрын үйл ажиллагаанд нөлөөлж, түүнийг ардын засгийн газрын хүчирхэг дайснуудын нэг хэмээн зарласан. Мөн өөрсдийн үйл ажиллагаанд саад болсон Бодоо зэрэг улс төрчидийг түүнтэй хамсаатан гэдэг үндэслэлээр хилсээр яллан хороож байв.

Иймээс Жаа ламыг устгах нь ардын засгийн газрын тулгамдсан асуудлуудын нэг болсон. Түүнийг устгасан хүмүүсийн тухай «монголд ажиллаж байсан халимаг сургагч Х. Б. Кануков, А. В. Хомутников нар далай ламын адислал авч ирлээ хэмээн хууран уулзаад буудан алсан», «Монголын дотоодын хамгаалахын дарга Балдорж өвчтөй хүн болж хууран адис авахдаа буудан алсан», «Дугаржав, Нанзад баатар нар 4 цэргийн хамт очиж Нанзад баатар буудан алсан» гэх мэтээр зөрөөтэй тэмдэглэсээр ирсэн.

Баримтаас харахад энэхүү ажиллагааг явуулах төлөвлөгөөг нийслэл хүрээний комендантаар ажиллаж байгаад Ховдын хязгаарын цэргийн штабын зөвлөх, штабын тагнуулын болон

улс төрийн хэлтэсүүдийн зөвлөхийн ажилд томилогдон ажиллаж байсан Халимаг сургагч «Х. Б. Кануков нууцаар боловсоруулан Монголын засгийн газарт тавьсан» [Дүнхэржав 2000: 11]-д Ардын засгийн газар 1922-оны 10 сарын 7-нд Мишигдорж бэйл болон ноён лам Дамбийжанцан нарыг хувилдан эх орноосоо урвасан гэдэг үндэслэлээр цэргийн шүүхээс цаазаар авах ял оноосоньг үндэслэн түүнийг устгах тухай 87 тоот дэлгэрэнгүй захирамж гарган уг ажиллагаатай холбогдуулан Ховдоос татан авч ирж Улиастай хотын камендант болгоод байсан энэхүү ажиллагааны удирдагч, зохион байгуулагч Х. Б. Кануковд маш нууцаар яаралтай явуулсан. Уг захирамжинд зааснаар бол «бүрэн эрхт төлөөлөгчид Дамбийжанцантай хэлэлцээ хийх дүр үзүүлэн түүнийг баривчлан аль болох түргэн устгаж, ард олныг зовлон гамшигаас салгах» ёстой байлаа. Мөн «Зүүн хязгаарын цэргийн даамал Дугаржав бэйс, хороон дарга Нанзад, дотоодыг хамгаалахын дарга Балдандорж нарыг дотоодын хамгаалахын 50 цэргийн хамт нууцаар томилон явуулсан тэд газар дээр нь очиж нууц төлөвлөгөө боловсоруулан Жа ламыг баривчилж, шүүхэд шилжүүлэн цаазар авах» [Пунцагноров 1960: 131] даалгавартай байсан. Уг ажиллагаанд оролцох төлөөлөгчидийг нууцлахын тулд «Дугаржавт засагт хан аймгийн цэргийг шалган байцаах түшмэл, Нанзадыг өөрийн эрхэлж байсан Улиастайн хуучин ажилдаа эргэн очихоор яваа, Балдандоржийг Улиастай зэрэг газрын цэргийн хороонуудад суртал нэвтэрүүлэгч комиссар гэсэн үнэмлэх бичиг шийтгэн олгосон» [Батбаяр 2014: 110] байна. Ийнхүү энэ ажиллагаа маш нууцаар эхэлсэн хэдий ч 1922-оны 10 сарын 10 өдөр ардын засгийн газраас «ард олонд хандан Дамбийжанцаны урьдаас аван үйлдэсэн муу хэргүүдийн тухай өгүүлэн түүнд цэргийн шүүхээс цаазар авах ял оноосон тул ардын засгийн газар түүнийг устгах арга хэмжээ авч байгаа. Дамбийжанцанд туслахыг хүссэн хэнийг ч болов буудан алах болно гэсэн» 77 тоот тунхагийг гарган [Пунцагноров 1960: 133] тараасан.

Балдандоржийн бүлэг Улиастайд ирж Х. Б. Кануковтай уулзан төлөвлөгөөгөө боловсоруулсан. Тэд Жа ламын итгэж хүндэлж явдаг Улиастайн сайд гүн С. Ламжав, Дилив худагт В. Жамсранжав нарын нэрээр «Өргөөгийн засгийн газар Жа ламын дэмжилгийг

хүсэж байгаа бөгөөд баруун хязгаарыг тохинуулах сайдын албан тушаал хашихыг урин түүнд хошуу нутаг, тамга тэмдэгийн хамт олгох» болсон тухай хуурамч захидал бичин Засагт хан аймагт морилон ирэхийг урьсан.

Жа лам хариуд нь «миний бие өвөл болгож байгаад очъё, харин одоохондоо хошуу ноёны тамга, тэмдэг, мөн түүнчлэн хэлэлцээ хийх төлөөний хүнийг яаравчилан хүлээе» [Батбаяр 2014: 112] гэсэн хариу явуулсан.

Ингэснээр Жа ламыг Засагт ханы өргөөнд ирхэд нь баривчлан устгах төлөвлөгөө бүтэлгүйтсэн. Энэ нь магадгүй Жа лам өөрт нь цэргийн шүүхээс цаазар авах ял оноон нууцаар даалгавар биелүүлэх хүмүүс явуулсан. Түүнд туслахыг хоргилсон тухай тунхагийг олж үзсэнээс хаширласан байж болох юм.

Иймд засгийн газрын тусгай төлөөлөгчид Засагт хан аймгийн өмнөд нутгуудаар цагаантаны дээрэмчид байгаа тухай худал мэдээлэл тараан түүнийг устгах нэрийн доор 1922-оны 11 сард Ховдын хорооноос тэнд сургагчаар ажиллаж байсан халимаг сургагч нар болон цэргүүд бүхий тавин хүний бүрэлдэхүүнтэй отьрядыг халимаг сургагч М. Лиджиевээр удирдуулан Жа ламын цайзын чиглэлд байх Гүн тамга гэдэг газар луу явуулсан. Мөн Улиастайгаас 50 цэргийг Баяр вангаар удирдуулан Итгэмжит бээлийн хошуу руу илгээсэн. Тэд Засагт хан аймгийн нутгийн урд талаар байх цагааны дээрэмчидтэй тэмцэх нэрийн доор Жа ламын цайз руу дөхсөөр байв.

1922-оны 12 сард Дугар бэйс, Нанзад баатар нар дөрвөн цэргийн хамт Жа ламын бэхлэлт рүү явсан тэд Жа ламыг урьсан урилгаас гадна салан тусгаарласан Тува нарыг номхоруулж өгөхийг хүссэн гуйлттай явж байв. Энэхүү төлөөлөгчид хэрвээ амь эрсдвэл Тэдний араас 25 цэргийн хамт явсан Балдандорж цагаантны дээрэмчидтэй тэмцэх нэрийн доор явж байсан 100 цэргийн хамт дайран орж эзлэх ба Мөн Улиастайн комендант, энэхүү ажиллагааны ерөнхий зохион байгуулагч Х. Б. Кануков Улиастай Ховдоос цуглуулсан 50 цэргийн хамт нэмэлт хүчээр очих байлаа.

Мөн энэ үед Улиастайн сайдын тушаалаар Итгэмжит бээлийн хошуунд Жа ламтай санал бодол нэгтэй хүмүүс болох Сартуул

цэцэн ван, Засагт хан зэрэг хүмүүсийг цуглуулсан нь нууц харуул хамгаалалтын доор Жа ламтанд газар нутгийг таслан өгөх зөвлөлгөөн хийх гэж байгаа гэж итгүүлэх хэрэг байсан. Нөгөө талаар эдгээр хүмүүсийг Жа ламд туслахаас сэргийлсэн хэрэг.

Нанзад нарын төлөөлөгчидийг эхний өдөр Жа лам баг харуул хамгаалалтын хамт хүлээн авсан бөгөөд тэдэнд ямар нэгэн үйлдэл хийх боломж гараагүй. Дугар бэйс түүнд итгэл олохын тулд «Халхын ард түмний байдал муу байгаагаас ардын засгийн газар итгэлгүй болж байгаа, өөрийг нь урьд цагаантантай нийлсэн гэдэг нэрээр гадуурхан хандах болсон ба Улаан халхчуудаас салах арга олохгүй байсан» зэргээр ярьхад Жа ламын байдал эрс өөрчлөгдөн харуул хамгаалалтаа гарган, «Баруун монголыг тохинуулах бүрэн эрхт сайдын тушаалыг хаших болно... энэ нь эргэлт хийхэд дөхөмтөй... монголыг эзлэх талаар Бээжинтэй ярьж тохирсон « [НА РК. Ф. Р-137. Оп. 1. Д. 2. Л. 89–92] зэргээр ярьсан байна. Дугар бэйст итгэсэн тэрээр өөрийн хүрээний байдал, бахархал болсон өөрийн хүмүүсийн буу зэвсэгийн агуулах, үнэт зүйлс, хувийн буу зэвсгээ хүртэл үзүүлэн 9 цагааны бэлэгийг тэдэнд өгсөн байна. Эцэст нь Дугар бэйс өөрт нь зориулан барьсан гэрт Жа ламыг урин газрын зургаар баримжаа олдог арга заана гэхэд тэрээр бие хамгаалагчаа орхин гэрт орсон байна. Тэднийг ороход цэрэг Даш адис авахаар сөхрөн унахад Жа лам уншлага уншин Дашийн толгой дээр адис тавихаар гараа сунгахад цэрэг Даш тэр гараас нь Дугар бэйс нөгөө гараас нь барьж авахад гал түлж байсан Нанзад баатар үсрэн босонгуутаа тулган буудахад сум хүзүүнд нь тусаж үхсэн байна. Уг үймээнээр гаднаас бие хамгаалагч нар нь орж ирсэн ч болж байгаа явдлыг хараад гарч зугатсан ба гадан үлдэсэн цэргүүд зэвсгийн агуулахыг эзлэн авч хий буудан сүрийг үзүүлсэнээр тэднийг буулган авсан байна. Жа лам нь хүнд итгэхдээ ихээхэн муу байсан тул энгийн үед хүмүүсийнхээ буу зэвсгийг хураан авч зэвсгийн агуулахад хадгалдаг байсан ба энэ агуулахаа Дугар бэйс нарт итгэн үзүүлсэн нь Дугар бэйсийн цэрэг хамгийн түрүүнд уг агуулахыг эзлэн авах боломжийг олгож улмаар энэ ажиллагаа ихээхэн үр дүнтэй болоход нөлөөлж, үймээн, зэвсэгт эсэргүүцлээс сэргийлж чадсан. Тэд Жа ламын ойрын 5 хүнийг олны нүдэн дээр буудан

алсан ба түүний хөрөнгө хогшил зэргийн хураан авсан. Дугар бэйс хамгийн үнэтэй зүйлсийг нь 6 хэсэг болгон хуваан авахаар шийдсэнээс Нанзад баатартай зөрөлдсөн. Улмаар Балдандоржийг ирэхэд энэ тухайгаа Дугар бэйс илтгэхэд Жа ламын бүх хөрөнгө болон 6 хэсэгт хуваан авахаар бэлдээд байсан зүйлсийг бүртгэн улсын санд хураан авсан. Ийнхүү энэ ажиллагаа амжилттай болсонд уг ажиллагааг зохион байгуулсан Х. Б. Кануков 1923 оны 1 сард энэхүү ажиллагааны тухай илтгэлийг засгийн газарт бичсэн ба 2 сарын сүүлээр Богдын хатаны толгойлсон хувьсгалын эсэргүү хэргийг илэрүүлэх хэргийн учираас Өргөөд дуудагдан очисон байна.

Эндээс харахад Дамбийжанцанг устгах ажиллагаанд тухайн үед Ховдын хязгаар болон Дотоодын хамгаалахад ажиллаж байсан халимаг сургагч нар оролцсон нь тодорхой байна. Ажиллагааг санаачлан төлөвлгөө зохиож, зохион байгуулан удирдасан хүн бол Х. Б. Кануков. Тус ажиллагаанд «Ховдын цэргийн хороонд сургагчаар ажиллаж байсан халимаг сургагч нар Монташ Лиджиевын отърядын бүрэлдэхүүнд багтан оролцосон бөгөөд эдгээр сургагч нараас Эренцэн Каблунов, Павел Жамбанов» [Бимбаев 1970: 61] нарын нэр мэдэгдэж байна.

Энэ ажиллганы тухай Рерих болон Хансленд нар Монгол Орос цэргийн хамтарсан хүчирхэг баг очиж устгасан тухай өгүүлсэн. Энэ орос цэргүүд гэдэг нь Халимагууд аж.

Х. Б. Кануков 1932-оны 10 сарын 22-нд бичсэн «Кануков Харти Бадиловичийн иргэний дайны байлдааны ажиллагаануудын тойм» гэсэн намтардаа «1922 оны 11 сард Төв Ази даяр алдаршсан луйварчин, амьд бурхан хэмээгдэгч Дамбийжанцанг Монгол улс болон Шинжаан, Алшаагийн торгууд нарын хилийн заагт байх өөрийнхөө байгуулсан цайзад 300 айлын хамт бүгэн суухад нь очиж устгах ажиллагааг удирдасан» [АВ ИВР РАН. Ф. 183. Оп. 1 Д. 16] гэсэн байдаг. Уг ажиллагаа дууссаны дараа армийн тагнуулын хэлтэст явуулсан түүний илтгэл 1924 оны 1 сард өргөөд хэвлэгдэж байсан Туяа сэтгүүлд хэвлэгдэсэн байна. Мөн 1922 оны 12 сард Дамбийжанцанг устгасан тухай мэдээ авсан Сүхбаатар

Балдандорж, Нанзад, Дугаржав, Сандуйжав нарт хандан баяр хүргээд «эрхэм түшмэдийн бие Вакунаев болон нийслэл хүрээнээс гарсан монгол торгууд цэргүүдийг авч гарсан зэвсгийн хамтаар даруй ирцгээхийг хүсэж, их баярын зүгээс эрхэм түшмэл Ба, На, Ду, Са нар танаа амрыг эрж бариулав» [МҮТА-МАНБТА. Ф.12. Д., ХН 181, 12] гэсэн захиаг явуулсан байдаг.

Дамбийжааг устгах ажиллагаатай холбогдосон өөр нэгэн халимаг хүн бол Дорж Дарминов юм. Тэрээр халимагаас монголд туслахаар ирсэн хоёр дахь хэсгийн бүрэлдэхүүнд багтан ирсэн юм. Түүнийг «Жа ламыг устгах тусгай даалгавар гүйцэтгэж байгаад баригдаж буудуулсан гэж ЗХУ-ын бүрэн эрхт элчин төлөөлөгч Виталий Иванович Юдин мэдэгдсэн» [Очиров 1970: 31] байдаг. Мөн 1923-оны 8 сар [Оглаев 1970: 90] болон 1924 онд Монголд байсан халимагуудын бүртгэлд түүний нэр байхгүй байна.

Эцэст нь дүгнэхэд Жа лам буюу Дамбийжанцанг устагах үйл ажиллагааны тухай засгийн газарт санал оруулж тухайн ажиллагааг ерөнхийд нь удирдасан хүн Х. Б. Кануков юм. Жа ламыг гардан устгасан хүмүүс нь Дугаржав, Нанзад, Даш нар бөгөөд Балдандорж нь Жа ламыг алсаны дараа өөрийн удирдаж явсан нэмэлт хүчний хамтаар ирж Жа ламын хөрөнгийн хураан авч данслах болон бусад зохион байгуулалтын үйл ажиллагааг хийсэн. Энэхүү ажиллагаанд нэмэлт хүчээр Ховд болон Өргөөгөөс татан авч ирсэн цэргийн бүрэлдэхүүнд тухайн үед монголд ажиллаж байсан халимаг цэргүүд байсан байна.

Архивын баримт

Монголын үндэсний төв архивын харьяа, Монгол Ардын Намын баримтын төв архив (МҮТА-МАНБТА). Ф. 12. Д., ХН 181. 12-р хуудас.

Архив востоковедов Института восточных рукописей РАН. Ф. 183. Оп. 1. Д.16.

Национальный архив Республики Калмыкия (НА РК). Ф. Р-137. Оп. 1. Д. 2. Л. 89–92.

Ашигласан ном

Батбаяр Б. Захчины түүх соёл судлалын асуудал. Эрхэлэн хэвлүүлсэн На.Сүхбаатар, Худам үсэгээс кирилл үсэгт буулгасан Г. Ядамжав. Bibliotheca orientica XXXVI. Улаанбаатар, 2014. 206 х.

Бимбаев М. Т. Дружба, рожденная революцией // С интернациональной миссией: воспоминания участников Монгольской народной революции / сост. Ю. О. Оглаев; под общ. ред. И. Я. Златкина. Элиста: Калм. кн. изд-во, 1970.

Дунхэржав Д. Балдандорж. Улаанбаатар, 2000. 40 с.

Ломакина И. В. Жа ламын толгой. Улаанбаатар, 2011. 239 х.

Монгол улс Завхан аймгийн он дараалалын бичиг. Улаанбаатар: Нэпко хэвлэлийн газар, 2013. 30 х.

Очиров Ц. М. Два года в Монголии: воспоминания участников Монгольской народной революции / сост. Ю. О. Оглаев; под общ. ред. И. Я. Златкина. Элиста: Калм. кн. изд-во, 1970.

С интернациональной миссией: воспоминания участников Монгольской народной революции / сост. Ю. О. Оглаев; под общ. ред. И. Я. Златкина. Элиста: Калм. кн. изд-во, 1970. 143 с.

Пунцагноров Ц. (ред.) Революционные мероприятия народного правительства Монголии в 1921–1924 гг / сост. Ц. Насанбалжир, М., 1960.

Перих Ю. Н. По тропам Срединной Азии. Хабаровск: Хабаровское книжн. изд-во, 1982. 304 с. ил.

Сүхбаатар На. (ред.) Дамбийжанцан баримт бичгийн эмхэтгэл (1912–1914). Bibliotheca Oiratica. Боть XXV. Улаанбаатар, 2012.